

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

2025 оны ... дугаар сарын ...

**“НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ”-ИЙН
2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Нийгмийн хамгааллын тусгай төв”-ийн

Дарга



Ш.Мөнхцэцэг

Улаанбаатар хот,
2025 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	02
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	02-10
ГУРАВ. АЛСЫН ХАРАА	10
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	10
ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛ.....	10
ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	10-13
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	13
НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ.....	14
ЕС.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15-17
АРАВ.ХАВСРАЛТ.....	18-23

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн Хуулийн 2 дугаар бүлгийн 16.1, 16.2, 16.4, 16.6, 16.7-д “Хүн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох эрхтэй” гэж заасан байдаг.

Төвийн стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажилалгааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө”-г үндэслэл болгож, төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг суурь үзүүлэлт болгон авч, шаардлагатай өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ярилцлага хийх, асуулга судалгаа авах аргаар мэдээлэл цуглуулан боловсруулалт хийв.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар”-ын дагуу Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Алхам 1. Нийгмийн хамгааллын тусгай төвийн чиг үүргийг тодорхойлох

Мандатын шинжилгээг тодорхойлохдоо Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 сарын 03-ны 117 дугаар тогтоолыг үндэслэв

Хүснэгт 1. Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль	21 хууль	
Үүнээс	Тухайн салбарын хууль	1
	Нийтлэг мөрдөгддөг хууль	20
Ерөнхий чиг үүрэг: Гэр оронгүй, гэр бүлээсээ дайжсан иргэдэд түр хоноглох, нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Гэр оронгүй, гэр бүлээсээ дайжсан зорилтот бүлгийн иргэдэд түр хоноглох үйлчилгээ үзүүлэх	1.1. Бүртгэл, судалгаанд хамруулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүрэг, хороо, ар гэр
	1.2. Хоол цай, усанд оруулах, хувцас солих зэрэг анхдагч хэрэгцээгээр хангах	
	1.3. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, хордлого тайлах, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт зуучлах	
	1.4. Нийгэм, сэтгэлзүйн анхан шатны үнэлгээнд хамруулж, үйлчилгээний чиглэлийг тодорхойлж богино хугацааны кейс менежментийн төлөвлөгөө гарган ажиллах	

	1.5. Асрамж, халамжийн төвүүд, ар гэр болон Сургалт хөгжлийн цогцолбор төвд хуваарилан хүргэж, дараагийн шатны үйлчилгээнд зуучлах	
2. Гэр оронгүй зорилтот бүлгийн иргэдэд нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх	2.1. Нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн хоёр дахь шатны үнэлгээнд хамруулж, үйлчилгээний чиглэлийг тодорхойлж урт хугацааны кейс менежментийн төлөвлөгөө гарган ажиллах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүрэг, хороо, ар гэр, АНБ
	2.2. Нийгэм, сэтгэл зүйн урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт хамруулах	
	2.3. Дондолтоос гаргах клиник суурьтай сэтгэл зүйн урт хугацааны хөтөлбөр болон эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах	
	2.4. Бие даан амьдрах арга ухааны хөтөлбөрт хамруулах	
	2.5. Ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, мэргэжлийн сургалтад хамруулж, түр болон тогтвортой ажлын байраар хангах, зуучлах, хуримтлалтай болгоход нь зөвлөн туслах	
	2.6. Ар гэрт нь эргэн нэгтгэх, бие даасан амьдралд шилжүүлэх	
3. Гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах	3.1. Салбарын байгууллагуудтай хамтран ажиллаж гэр оронгүй иргэдэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайжруулах, арга зүйг хөгжүүлэх, технологийн дэвшилд суурилан олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Их сургуулиуд, салбарын эрдэмтэн судлаачид, дүүрэг, хороо, ар гэр, АНБ
	3.2. Орон нутгийн засаг захиргаа, төрийн үйлчилгээний холбогдох байгууллагуудтай хамтран гэр оронгүй иргэдийн талаар судалгаа хийж ажиллах.	
	3.3. Гэр оронгүй иргэдийн талаарх судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний зөвлөмж боловсруулж тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд хүргүүлж ажиллах.	

Нийгмийн хамгааллын тусгай төв нь хуулийн хүрээнд 15 үндсэн чиг үүрэг, 15 дэд чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид тулгуурлан тодорхойлсон бөгөөд тухайн чиг үүргийг захиргааны эрх хэмжээний ангиллаар авч үзсэн. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг суурь болгон үзвэл дараах байдлаар гарч ирнэ:

- **Бодлого боловсруулах** – Үндэсний хэмжээний болон салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээр Засгийн газар, яамд болон нутгийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээ хамаарна.
- **Зохицуулалт хийх** – Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.

- **Зохион байгуулах** – Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.
- **Санхүүжилт** – Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.
- **Хүний нөөцийн бодлого** – Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.
- **Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх** – Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шинжилгээ болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.
- **Үйлчилгээ үзүүлэх** – Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн чиг үүргийг авч үзвэл дараах байдалтай байна.


Хүснэгт 2. Чиг үүрэг, эрх хэмжээ

№	Чиг үүрэг	Захиргааны хэм хэмжээ						
		Бодлого боловсруулах	Зохицуулалт хийх	Зохион байгуулах	Санхүүжилт	Хүний нөөцийн	Хяналт, үнэлгээ хийх	Үйлчилгээ үзүүлэх
1	Гэр оронгүй иргэдийг хүлээн авч, халуун хоол цай, хоноглох байраар үйлчилж, ахуйн хэрэглээний материал, хувцас олгож, усанд оруулах, дархлаа дэмжих хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, амин дэмээр хангах үйлчилгээг үзүүлнэ.			✓	✓	✓	✓	✓
2	Нийслэлийн хэмжээнд гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгч, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлж, төрөл бүрийн сургалтад хамруулна			✓	✓	✓	✓	✓
3	Иргэний бүртгэлгүй, бичиг баримтгүй тэнэмэл иргэдийн иргэний бичиг баримтыг тодорхой хаягтай болгон бүрдүүлж, зөрчилгүй болгоно.			✓	✓	✓	✓	✓
4	Тэнэмэл амьдралтай иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, архины хамааралтай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нөхөн сэргээх, хордлого тайлах үйлчилгээг тус тус үзүүлэн, дараагийн шатлалын эмнэлэгүүдэд зуучлан улирал бүр нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулна.			✓	✓	✓	✓	✓
5	Төвөөр үйлчлүүлж буй гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажил мэргэжлийн чиг баримжаа			✓	✓	✓	✓	✓

	олгох, мэргэжил эзэмшсэн үйлчлүүлэгч иргэдийг ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах зээлд төлөвших нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.							
6	Гэр оронгүй үйлчлүүлэгч иргэдийн мэргэжил, ур чадвар, онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрт хамруулах замаар нийгмийн оролцоог дэмжин ажиллана.			✓		✓	✓	✓
7	Гэр оронгүй үйлчлүүлэгч иргэдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг харьяа цагдаагийн хэлтэстэй хамтран зохион байгуулна.			✓		✓	✓	✓
8	Хөдөө орон нутгаас нийслэлд оршин суух бүртгэлгүй, орон гэргүй, тэнэмэл иргэдийг орон нутгийн байгууллагатай хамтран нийгмийн халамжийн зохих үйлчилгээнд хамруулан ажиллана.			✓	✓	✓	✓	✓
9	Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэм, хамт олны дунд төлөвшүүлэх ажилд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, энэ талаар гаргасан аливаа санал санаачлагыг дэмжиж ажиллана.			✓	✓	✓	✓	✓
10	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэд гэр бүл болж бие даан амьдрах бусад нөхцөлийг бий болгоход холбогдох байгууллагууд, ар гэртэй нь хамтран шийдвэрлэнэ.			✓	✓	✓	✓	✓
11	21-ээс дээш насны гэр оронгүй, тэнэмэл иргэдийг бүртгэж, судалгаа статистик мэдээ, баримтыг боловсруулан холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцож хамтран ажиллана.			✓	✓	✓	✓	✓
12	Гэр оронгүй тэнэмэл иргэдийг зохих нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулна.			✓	✓	✓	✓	✓
13	Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдээс үүдэлтэй ард иргэдийн амгалан, тайван амьдрах нөхцөлийг хангахад, Улаанбаатар хотын цагдаагийн газар, дүүргүүдийн цагдаагийн хэлтэстэй хамтран ажиллана.			✓		✓	✓	✓
14	Нийгмийн гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн хэмжээнд байгаа гэр оронгүй иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд Нийслэлийн Эрүүл мэндийн газар, ХӨСҮТ, Аддиктологийн төв, СЭМҮТ, Энэрэл эмнэлэг, дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдэлүүдтэй хамтран ажиллана.			✓	✓	✓	✓	✓
15	Засгийн газар, яам, агентлаг, Нийслэлийн ЗДТГ-аас хэрэгжүүлж буй гэр оронгүй тэнэмэл иргэдэд хөтөлбөр арга хэмжээнд санал оруулах мөн хөтөлбөр санаачилж болно.			✓		✓	✓	✓

Холбогдох талуудыг тодорхойлохдоо Нийгмийн хамгааллын тусгай төвийн бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв.

Зураг 1. Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагаанд холбогдогч талууд



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах, гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Өөрөөр хэлбэл Нийгмийн хамгааллын тусгай төв нь хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдгээр холбогдогч талуудтай харилцах бөгөөд холбогдогч талууд өөрт хамаарах эрх хэмжээний хүрээнд үүрэг оролцоотойгоор хамтран ажиллана. Үүнийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт-3. Холбогдогч талуудын оролцоо

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Үйлчлэх	Хяналт тавих
Нийслэлийн Засаг дарга	✓	✓	✓	✓		
Нийслэлийн ЗДТГ	✓	✓	✓	✓		
Яам, агентлаг		✓	✓	✓		
НИТХ			✓	✓		
Нийслэлийн Захирагчийн ажлын алба			✓	✓		
Нийслэлийн Эрүүл мэндийн газар			✓	✓		
Нийслэлийн Энэрэл эмнэлэг, Аддиктологийн эмнэлэг, ХӨСҮТ			✓	✓		

Нийслэлийн Цагдаагийн газар	✓		✓	✓		
Дүүргүүдийн цагдаагийн газар	✓		✓	✓		
Дүүргүүдийн ЗДТГ			✓	✓		
Дүүргүүдийн ХХҮХ			✓	✓		
Дүүргүүдийн хороод		✓		✓		
Батсүмбэр дэх Ахмадын асрамжийн газар		✓		✓		
Сургалт, судалгааны байгууллага			■	✓	■	
Аж ахуйн нэгж			■	✓	■	
Иргэд		■		✓	■	■
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	■			✓		

Чиг үүргийн хэрэгжилтийн талаарх үнэлгээг гаргахдаа Нийгмийн хамгааллын тусгай төвийн ажилтнууд болон холбогдох талуудын дунд явуулсан санал асуулгын үр дүнд тулгуурласан.

Хүснэгт-3. Нийгмийн хамгааллын тусгай төвийн чиг үүргийн хэрэгжилт

№	Үндсэн чиг үүрэг	Албан хаагчдын үнэлгээ (хувиар)	Холбогдогч талуудын үнэлгээ (хувиар)	Дундаж үнэлгээ (хувиар)
Нэг. Үндсэн чиг үүрэг				
1.1	Төвд гэр оронгүй иргэдийг хүлээн авч, халуун хоол цай, хоноглох байраар үйлчилж, ахуйн хэрэглээний материал, хувцас олгож, усанд оруулах, дархлаа дэмжих хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, амин дэмээр хангах үйлчилгээг үзүүлнэ.	90	86	88
1.2	Нийслэлийн хэмжээнд гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгч, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлж, төрөл бүрийн сургалтад хамруулна	80	70	75
1.3	Иргэний бүртгэлгүй, бичиг баримтгүй тэнэмэл иргэдийн иргэний бичиг баримтыг тодорхой хаягтай болгон бүрдүүлж, зөрчилгүй болгоно.	80	74	77
1.4	Тэнэмэл амьдралтай иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, архины хамааралтай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нөхөн сэргээх, хордлого тайлах үйлчилгээг тус тус үзүүлэн, дараагийн шатлалын эмнэлэгүүдэд зуучлан улирал бүр нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулна.	100	96	98

1.5	Төвөөр үйлчлүүлж буй гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил эзэмшсэн үйлчлүүлэгч иргэдийг ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах зээлд төлөвших нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	80	60	70
1.6	Гэр оронгүй үйлчлүүлэгч иргэдийн мэргэжил, ур чадвар, онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрт хамруулах замаар нийгмийн оролцоог дэмжин ажиллана.	60	40	50
1.7	Гэр оронгүй үйлчлүүлэгч иргэдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг харьяа цагдаагийн хэлтэстэй хамтран зохион байгуулна.	90	80	85
1.8	Хөдөө орон нутгаас нийслэлд оршин суух бүртгэлгүй, орон гэргүй, тэнэмэл иргэдийг орон нутгийн байгууллагатай хамтран нийгмийн халамжийн зохих үйлчилгээнд хамруулан ажиллана.	70	60	65
1.9	Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэм, хамт олны дунд төлөвшүүлэх ажилд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, энэ талаар гаргасан аливаа санал санаачлагыг дэмжиж ажиллана.	60	50	55
1.10	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэд гэр бүл болж бие даан амьдрах бусад нөхцөлийг бий болгоход холбогдох байгууллагууд, ар гэртэй нь хамтран шийдвэрлэнэ.	60	48	56
1.11	21-ээс дээш насны гэр оронгүй, тэнэмэл иргэдийг бүртгэж, судалгаа статистик мэдээ, баримтыг боловсруулан холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцож хамтран ажиллана.	70	74	72
1.12	Гэр оронгүй тэнэмэл иргэдийг зохих нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулна.	85	90	87,5
Хоёр. Дэд чиг үүрэг				
2.1	Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдээс үүдэлтэй ард иргэдийн амгалан, тайван амьдрах нөхцөлийг хангахад, Улаанбаатар хотын цагдаагийн газар, дүүргүүдийн цагдаагийн хэлтэстэй хамтран ажиллана.	90	80	85
2.1	Нийгмийн гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн хэмжээнд байгаа гэр оронгүй иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд Нийслэлийн Эрүүл мэндийн газар, ХӨСҮТ, Аддиктологийн төв, СЭМҮТ, Энэрэл эмнэлэг, дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдлүүдтэй хамтран ажиллана.	95	90	92,5
2.3	Засгийн газар, яам, агентлаг, Нийслэлийн ЗДТГ-аас хэрэгжүүлж буй гэр оронгүй тэнэмэл иргэдэд хөтөлбөр арга хэмжээнд санал оруулах мөн хөтөлбөр санаачилж болно.	80	70	75
Ерөнхий дундаж үнэлгээ		79,3%	71,2%	75,4%

Нийгмийн хамгааллын чиг үүргийн хэрэгжилтийн дундаж үнэлгээг ерөнхий чиг үүргээр багцлан харвал үйлчлүүлэгч иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ хамгийн өндөр (98%), үйлчлүүлэгч иргэдийг мэргэжил ур чадвар хэрэгцээнд тохирсон төсөл хөтөлбөрт хамруулах үйлчилгээ хамгийн бага (50%) үнэлгээтэй байна.

Үйлчлүүлэгч иргэдийн мэргэжил ур чадварыг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгож, иргэдийг хамруулах чиглэлийн мөн бусад чиглэлийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт доогуур үзүүлэлттэй байгаа тул анхаарч ажиллах шаардлагатайг илэрхийлж байна.

Мэргэжил, мэдлэг, ур чадвартай иргэдийн нөөц боломжийг хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн үйл ажиллагаанд татан оролцуулах боломж байгаа нь харагдаж байна.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Алсын хараа

Ухамсарт иргэн- Бүтэн гэр бүл- Амар тайван нийгэм

Уриа

Хариуцлагатай Монгол хүн – Хамтдаа бүтэн гэр бүлийн төлөө

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Иргэн бүрийн ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж, нийгмийн цогц үйлчилгээг үзүүлэх замаар хувь хүний хөгжлийг дэмжих.

ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛ:

Нийгэм, сэтгэл зүйн хувьд өөрчлөгдсөн, хөгжсөн, хөдөлмөрч, бие даасан иргэн

Үйл ажиллагааны зарчим:

- **Хүмүүнлэг энэрэнгүй байх** - Иргэдийн ялгаатай байдалд адил тэгш хандах
- **Хууль дээдлэх** - Хуульд нийцсэн шийдвэр гаргаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
- **Ил тод байх** - Хуулиар нууцын зэрэглэлд хамаарахаас бусад мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод , ойлгомжтой байх
- **Тэгш шударга байх** - Нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хувь хүний эрхийг дээдлэх
- **Мэргэшсэн, хариуцлагатай байх** - Мэдрэмжтэй, хариуцлагатай, бусдыг сонсдог, зөвлөн туслагч байх
- **Судалгаанд суурилсан бодитой байх**- Судалгаанд суурилсан төлөвлөлт хийх
- **Мэдлэг инновацыг эрхэмлэх**- Шинэ санаачилгыг дэмждэг, нэвтрүүлдэг байх
- **Эко орчин- ногоон хөгжлийг дэмжих** – Байгальд ээлтэй үзлийг дэмжиж, хүн бүр мод тарих аянд түүчээлэх

ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээний үндсэн зорилго нь байгууллагын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, цаашлаад тухайн байгууллагын стратегийн төлөвлөгөөний гол үндэслэл болдог. Байгууллагын дотоод орчны чадавхыг үнэлж, гадаад орчныг шинжлэх зорилгоор байгууллагын үндсэн элементүүдийн давуу ба сул тал, гадаад орчны боломж, эрсдэлийг судалгааны үндэслэлтэй тодорхойлоход оршино. Ингэснээр стратегийн шийдвэр гаргах, мэдээллээр хангагдах боломжтой болно. Үүнийг Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 7 дахь хэсэгт зааснаар Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төвийн орчны шинжилгээг

байгууллагын мандатад үндэслэн SWOT шинжилгээний аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн дотоод орчны шинжилгээг хийхдээ байгууллагын бүтэц, зохион байгуулалт, соёл, нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл) хийгээд технологийн үйл явц зэрэг хүчин зүйлсийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойлсон.

Харин гадаад орчны шинжилгээгээр улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлсноор ямар боломж, эрсдэл байгааг тодорхойлсон.

Хүснэгт-4

CROSS SWOT АНАЛИЗ

Дотоод хүчин зүйл	
Давуу тал	Сул тал
- Зорилтот бүлгийн иргэдэд танигдсан - Мэргэжлийн албан хаагчид, хүний нөөцтэй - Хүний нөөц харьцангуй тогтвортой ажилладаг - Хүний нөөцийн ур чадвар өндөр - Судалгаа шинжилгээ хийх мэдээллийн сан зохих хэмжээнд бүрдсэн - Төв өөрийн эзэмшлийн байр, газартай - Байгууллагын үйлчилгээний стандарттай - Байгууллага сургалт үйл ажиллагааны хөтөлбөр, иргэд хүлээн авч байрлуулах журам зэрэг үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дүрэм, журам бүрдсэн - Шаардлагатай үед үйлчлүүлэгч иргэдээс богино цагаар ажиллах хүч гарах боломжтой. - Тогтмол төсвийн санхүүжилттэй - Жилийн 4 улиралд тасралтгүй ажиллах боломжтой	- Зорилтот бүлгийн үйлчлүүлэгч архины хамаарал өндөр, сөрөг хандлагатай, бие хүний эвдрэлтэй - Ажилтнууд биеийн болон сэтгэл зүйн хувьд түгшүүр, эрсдэлтэй орчинд ажилладаг - Цаг үеийн асуудлаар арга хэмжээ зохион байгуулах зардал төсөвт суудаггүй - Сургалтын зардал төлөвлөдөг боловч батлагддаггүй - Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж дутмаг - Зорилтот бүлгийн иргэд халдварт болон халдварт бус өвчлөл ихтэй
Гадаад хүчин зүйл	
Боломж	Эрсдэл
- Төв нь насанд хүрэгчдийн нийгмийн хамгааллын чиглэлийн төрийн үйлчилгээний үндэсний хэмжээний байгууллага. - Олон улсын туршлага, арга зүйг судлах мэдээ мэдээлэл авах боломж нээлттэй - Иргэд, аж ахуйн нэгж, ОУБ-ууд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломжтой - Халамж асрамжийн үйл ажиллагаа явуулдаг олон улсын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой	- Зорилтот бүлгийн иргэдтэй ажиллах хууль эрх зүйн орчин дутмаг тул үйлчилгээний явцад эрсдэл нөхцөлүүдэд үүсэх магадлалтай - Нийгмийн хандлага зорилтот бүлэгт нийгмийн сөрөг хандлага давамгайлсан тул хамтын үйл ажиллагаанд хүндрэл үүсэх талтай - Зорилтот бүлгийн иргэдийн дийлэнх нь архины хамаарал өндөр, тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээл зонхилсон тул ажлын байрны зуучлалд хүндрэл үүсэх эрсдэлтэй - Нийгэм эдийн засгийн тогтворгүй байдал, хямрал, ядуурал, өвчлөл, цар тахал зэргээс шалтгаалах гэр оронгүй иргэдийн тоо нэмэгдэж болзошгүй

SWOT шинжилгээ нь байгууллагын дотоод давуу болон сул тал, гадаад орчны боломж ба аюул заналыг илрүүлэн тодорхойлох стратегийн чухал хэрэгсэл юм. Энэхүү шинжилгээний зорилго нь байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, цаашдын хөгжлийн стратегийг оновчтой төлөвлөхөд оршино. SWOT шинжилгээ хийснээр байгууллага дотоод нөөц боломжоо бүрэн ашиглах, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, мөн гадна орчны эерэг боломжийг ашиглан сөрөг нөлөөллөөс сэргийлэх суурь мэдээллийг олж авдаг. Иймд SWOT шинжилгээ нь стратеги төлөвлөгөө боловсруулах үйл явцын үндэс болж өгдөг бөгөөд байгууллагын удирдлагад шийдвэр гаргахдаа баримтлах бодит үндэслэл, нотолгоог бүрдүүлдэг.

Энэхүү тайланд Нийгмийн хамгааллын тусгай төвийн бүтэц, салбар, нэгжүүдийн (Дамжин өнгөрүүлэх төв, Сургалт хөгжлийн цогцолбор төв, Нийгэм, сэтгэл зүйн алба, Захиргаа хүний нөөцийн удирдлагын алба, Эрүүл мэндийн алба, Аж ахуйн алба зэрэг) орчны шинжилгээнд үндэслэн, тус төвийн SWOT шинжилгээний нэгтгэсэн дүгнэлтийг дэлгэрэнгүй боловсрууллаа. Тус төв нь Нийслэлийн Засаг даргын дэргэдэх бие даасан байгууллага бөгөөд нийслэл хотын хэмжээн дэх гэр оронгүй, тэнэмэл амьдралтай нийгмийн хамгийн эмзэг бүлгийн иргэдэд нийгэмд бие даасан амьдралд шилжихэд нь дэмжин туслах, нийгмийн анхдагч, хамгааллын үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй юм.

Гадаад орчны хувьд SWOT шинжилгээг баяжуулан PESTLE шинжилгээ давхар хийх замаар тодорхойллоо.

Үзүүлэлт	Хамрах гол эерэг, сөрөг хүчин зүйлс	Нэмэлт тайлбар
Улс төр	- Гэр оронгүй иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн статустай ганц байгууллага, нийслэлд харьяалагддаг - Удирдлагын шууд дэмжлэг - Улс төрийн тогтворгүй байдал	Төв нь Нийслэлийн Засаг даргын дэргэдэх байгууллага тул хотын удирдлага солигдох, бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан байгууллагын удирдлага гэнэтийн байдлаар солигдох, албан хаагчдын тогтвортой байдал бий болох зэрэг эрсдэлтэй. Гэхдээ хууль, захирамжаар тогтоосон статус нь бүтэц, чиг үүргийг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлж байна.
Эдийн засаг	- Олон улсын салбарын дунджаас харьцангуй бага цалин хөлс - Төсөв, санхүүгийн тогтвортой байдал - Эдийн засгийн хямралын эрсдэл	Байгууллага санхүүгийн хувьд сайн нөхцөлтэй ч улс орны эдийн засгийн хямрал нь төсөвт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
Нийгэм	- Үйлчлүүлэгчид нийгэмд биеэ зөв авч явах, нийгмийн соёл, ухамсар нэн дутмаг. - Сурч хөгжих боломж - Хамт олны уур амьсгал, уян хатан бус цагийн бодлого - Нийгмийн баталгааны боломж сул	Үйлчлүүлэгчдийг нийгэмд гадуурхах хандлага түгээмэл байдаг тул тэднийг бие даасан амьдралд шилжүүлэхэд хугацаа их шаарддаг. Ажлын байран дээрх ур чадвар, мэргэжил дээшлүүлэх, харилцаа хандлага, хувь хүний хөгжлийн сургалтуудад хамрагдах боломжоор дэмжлэг үзүүлдэг удирдлагын

		тогтолцоо нь чадварлаг хүний нөөцийн бүрэлдэхүүн байхад ихээхэн нөлөөлдөг. Цагийн хатуу бодлого нь орчин үеийн амьдралын хэв загвар, ажлын байрны онцлог нөхцөлд суурилан уян хатан бодлогод шилжих хэрэгцээг үүсгэж байгаа. Албан хаагчдын нийгмийн баталгаанд анхаарах, хөнгөлөлттэй нөхцөл бүхий орон сууц, газар, байшин зэрэг бодит томоохон зүйлээр дэмжих хэрэгцээ тулгамдсан.
Технологи	▪ Интернэт, дотоод сүлжээний хүндрэл ▪ Орчин үеийн программ хангамжийн хэрэглээ ▪ Бүртгэлийн программыг цахим хувилбарт шилжүүлэх боломж	Дотоод сүлжээ сул, мэдээллийн аюулгүй байдал хангагдаагүй, бүртгэлийн программ цахим хувилбарт шилжээгүй, цахим хувилбарт шилжих шаардлага үүссэн.
Хууль эрх зүй	▪ Тогтоол, захирамжаар баталгаажсан статус ▪ Зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн орчин дутмаг байдал	Байгууллагын үйл ажиллагаа эрх зүйн үндэслэлтэй боловч зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд хууль эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлага үүссэн.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО


Нийгмийн хамгааллын тусгай төвийн орчны шинжилгээний үр дүнгээр “хөгжлийн стратеги”-ийг баримтлах нь оновчтой байна. Хөгжлийн стратеги нь байгууллагын ерөнхий үйл ажиллагааны чанар, хөгжилд анхаарч үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, өсөж хөгжих, байр сууриа бэхжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн үр дүнд анхаарч ажиллахад чиглэнэ.

Тодруулбал Нийгмийн хамгааллын тусгай төв нь хөгжлийн стратегийн хүрээнд давуу талдаа тулгуурлан боломжийг нэмэгдүүлэх, эрсдэлд өртөхгүй байхаар зорилго үйл ажиллагаагаа төлөвлөж ажиллах нь чухал юм.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах стратегийн зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

1. Холбогдох хуулийн хүрээнд төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний стандарт нэвтрүүлнэ.
2. Үйлчлүүлэгч иргэдийн амьдралын буруу дадал, хэвшлийг өөрчлөх, бие даасан амьдралд бэлтгэх сургалт, хөгжил, соёлын цогц арга зүй, хөтөлбөрийг хөгжүүлж, хэрэгжүүлнэ.
3. Ажлын байр, мэргэжлийн сургалт, бүтээлч үйл явцыг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, бие даасан амьдралд шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ.
4. Салбарын болон олон улсын судалгаанд суурилсан арга зүйг хөгжүүлж, нийгэмд гэр оронгүй иргэд нэмэгдэн бий болохоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллана.
5. Тогтвортой хөгжилт тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогын хэрэгжүүлнэ

НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ



ЕС. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт	Арга зам	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
1.Холбогдох хуулийн хүрээнд төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний стандарт нэвтрүүлнэ.	1.1.Зорилтот бүлэгт хүргэж буй төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ	1.Зорилтот бүлгийн иргэдийг хүлээн авч үйлчилгээ үзүүлэх орны тоо	130	330	Батлагдсан төсөв
		2.Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь	80	85	
	1.2.Үйлчлүүлэгчдийн онцлогт тохирсон шаталсан үйлчилгээг нэвтрүүлж эхэлнэ	1.Стандарт хангагдсан орчинд үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн хувь	0	70	
2.Үйлчлүүлэгч иргэдийн амьдралын буруу дадал, хэвшлийг өөрчлөх, бие даасан амьдралд бэлтгэх сургалт, хөгжил, соёлын цогц арга зүй, хөтөлбөрийг хөгжүүлж, хэрэгжүүлнэ.	2.1.Стандарчлагдсан нийгэм сэтгэл зүйн цогц арга зүй, хөтөлбөрийг төвийн үйлчилгээнд нэвтрүүлнэ.	1.Төвөөр үйлчлүүлэгч иргэдээс нийгэм сэтгэл зүйн цогц хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үзүүлэлт-хувиар	20	80	Батлагдсан төсөв
		2.Төвөөр үйлчлүүлэгчдийн бие даасан амьдралд шилжиж буй үзүүлэлт-хувиар	5	15	
3.Ажлын байр, мэргэжлийн сургалт, бүтээлч үйл явцыг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, бие даасан амьдралд шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ.	3.1.Сургалт хөгжлийн төвийг түшиглэн үйлчлүүлэгч иргэдэд ажлын байр бий болгоно	1.Шинээр бий болгосон ажлын байрны тоо	5	100	Батлагдсан төсөв
	3.2.Үйлчлүүлэгч иргэдийг мэргэжлийн сургалтад хамрагдах бүхий л орчинг бүрдүүлсэн байна	1.Шинээр бий болгосон мэргэжлийн сургалтын тоо	0	10	
		2.Мэргэжлийн сургалтад хамрагдаж, мэдлэг, туршлага, чадвар эзэмшсэн иргэдийн тоо	0	100	
	3.3.Үйлчлүүлэгчийн мэргэжил, чадвар, сонирхолд тохирсон тогтвортой ажлын байрны зуучлалыг нэмэгдүүлж, хуримтлалтай болгоно.	1.Ажлын байраа тогтвортой хадгалж үлдсэн иргэдийн хувь	10	50	
		2.Таван сая төгрөгөөс дээш хуримтлалтай болсон иргэдийн тоо	2	20	
		1.Урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн дүүргийн тоо	0	9	

4.Салбарын болон олон улсын судалгаанд суурилсан арга зүйг хөгжүүлж, нийгэмд гэр оронгүй иргэд нэмэгдэн бий болохоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллана.	4.1.Гэр оронгүй иргэд нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх арга зүй, хөтөлбөр болосруулж, хэрэгжүүлэх	2.Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн тоо /4 жилээр/	35	300	Батлагдсан төсөв
	4.2.Төрийн байгууллага, хувийн аж ахуйн нэгжүүд, их сургууль, судалгааны байгууллагуудтай нийгмийн эрүүл мэндийн дархлааг дэмжих чиглэлээр хамтран ажиллана.	1.Хамтран хэрэгжүүлсэн нөлөөллийн ажлын тоо	0	5	Батлагдсан төсөв
		2.Нөлөөллийн ажлын үр шимийг хүртсэн иргэдийн тоо	0	10,000	
5.Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна	5.1.Төвийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг “Алсын хараа-2050” болон нийслэлийн хөтөлбөртэй уялдуулан сайжруулах	1.Стратегийн матриц бүрэн боловсруулсан байдал (%)	0	100	Батлагдсан төсөв
		2.Cascading Goals-ийн түвшнүүдийн нэгдмэл байдал(%)	0	80	
6.Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ	6.1.Хамт олны дунд эерэг, иргэн төвтэй, инновацат соёлыг “Transformation Leadership” аргаар төлөвшүүлэх	1.Манлайллын сургалт, коучингийн тоо (жилд)	0	2	Батлагдсан төсөв
		2.Үнэт зүйлсийн өдөр зохион байгуулсан тоо (жилд)	0	2	
7.Оролцогч талуудын оролцоог хангана.	7.1.Олон нийтийн оролцоог “ил тод, нээлттэй байдлаар” фокус групп, форум API-ээр тасралтгүй хангах	1.Форум/фокус группийн тоо (жилд)	0	2	Батлагдсан төсөв
		2.API ашиглагдсан тоо	0	2	
	7.2.Дотоодын болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	1.Хамтын ажиллагаатай байгууллагын тоо	5	15	Батлагдсан төсөв
		2.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	40	80	
	7.3.Төвийн үйл ажиллагааг сурталчлан таниулах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	1.Бэлтгэн гаргаж, олон нийтэд түгээсэн контентийн тоо	6	20	
		2.Нийгмийн сүлжээний хандалтын тоо (нийт 4 жилийн хугацаанд)	3,000	20,000	
		1.Хэрэгжсэн инновацийн төсөл тоо	2	4	

8.Тогтвортой үнэ цэнийг бий болгоно	8.1.Инновац, технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, ажлын үр дүн, хүртээмж, байгаль-нийгмийн үр ашгийг дээшлүүлэх.	2.“Social & Green Impact” үнэлгээний тайлангийн тоо	0	2	Батлагдсан төсөв
9.Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдагыг сайжруулна.	9.1.Хүний нөөцийн бодлого, PDCA/OKR аргачлалыг нэгтгэн гүйцэтгэл-өөрчлөлтийн тогтолцоог бэхжүүлэх	1.Хүний нөөцийн бодлогын шинэчлэлийн тоо (жилд)	0	1	Батлагдсан төсөв
		2.PDCA мөчлөгийн дэвшилт (%)	0	80	
	9.2.Байгууллагын шинэ өргөтгөл, бүтэц үйл ажиллагааны шинэчлэлтэй уялдуулан удирдлагын бүрэлдэхүүний мэргэжлийн хөгжлийг дэмжиж, зохион байгуулалтын шинэлэг арга барил нэвтрүүлнэ	1.Нэг ажилтанд ногдох чиг үүргийн давхардал буурсан, ажлын байран дээрх сэтгэл ханамжийн үзүүлэлтийн хувь	70	90	
	9.3.Хүний нөөц, нийгмийн баталгааны хөтөлбөрийг стратеги төлөвлөгөөнд суурилан хөгжүүлж, хэрэгжүүлнэ.	1.Хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	70	90	Батлагдсан төсөв
		2.Гадаадад сургалтад хамрагдсан тоо (жилд)	2	10	
		3.Эрдмийн зэрэг ахиулах сургалтад хамрагдсан тоо	3	5	
		4.Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	30	80	
		5.Хөнгөлөлттэй нөхцөл бүхий орон сууцанд хамрагдсан тоо (жилд)	0	5	
10.Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголт	10.1.Оролцогч талуудын (иргэд, ААН, ТББ) сэтгэл ханамж, стратеги-хүрээний ойлголтыг “SERVQUAL”-аар тогтмол үнэлэх	1.Сэтгэл ханамжийн дундаж тоо	0	2	Батлагдсан төсөв
		2.Оролцогчдын судалгаанд оролцсон хувь (%)	0	80	

АРАВ. ХАВСРАЛТ

Нийгмийн хамгааллын тусгай төвийн товч танилцуулга

Төв нь 21-ээс дээш насны өөрийн гэсэн орон гэргүй, орлого нь хязгаарлагдмал, эрхэлсэн тодорхой ажилгүй, харж хандах хүнгүй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг нийгэмшүүлэх, тэднийг бие даасан амьдралд шилжихэд нь туслан дэмжих зорилготойгоор 2003 оноос хойш Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн үйлчилгээний байгууллага юм.

Тус төв нь нэг дор 150 иргэн хүлээн авч байрлуулах хүчин чадалтай бөгөөд жилд эмзэг бүлгийн гэр оронгүй 500-650 иргэнийг байрлуулан нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлж, жил тутам 25-30 орчим иргэн тус төвөөр дамжин бие даасан амьдралд шилжиж байна.

Сүүлийн 10 жилийн статистикийг авч үзвэл нийт 3340 иргэнийг төвд байрлуулж, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулсан бөгөөд энэ хугацаанд нийт 2400 иргэн гэр оронгүй болж, шинээр бүртгэгдсэн байна. Түүнчлэн өнгөрсөн 10 жилд нийт 294 иргэнийг бие даасан амьдралд шилжүүлж, 676 иргэнийг бичиг баримтжуулж, 1240 иргэнийг ажлын байранд зуучлан орлогын эх үүсвэрийг нь нэмэгдүүлэн ажилласан байна.

Хүний нөөцийн чадамжийн судалгаа

1. Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүд

СЭМ-ийн үзлэгт 23-59 насны, 27 албан хаагч хамрагдсанаас 44.4% (n=12) нь эрэгтэй, 55.6% (n=15) нь эмэгтэй, хүйсийн харьцаа (1:1.2), 62.9% (n=17) нь дээд боловсролтой, 59.3% (n=16) нь гэр бүлтэй, 40.7% (n=11) нь нөхөр/эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг, 70.4% (n=19) нь ажилд ороод 5 жил болоогүй байв (Хүснэгт-1).



Хүснэгт -1. СЭМ-ийн үзлэгт хамрагдсан албан хаагчдын хүн ам зүйн ерөнхий үзүүлэлт

Үзүүлэлт			Насны бүлэг				Нийт N (%)
			21-30 (n=3)	31-40 (n=9)	41-50 (n=4)	51< (n=11)	
Хүйс							
Эрэгтэй			0	4	1	7	12 (44.4)
Эмэгтэй			3	5	3	4	15 (55.6)
Боловсрол							
Бүрэн	бус	дунд	0	0	0	2	2 (7.4)
Бүрэн		дунд	0	1	1	5	7 (25.9)
Тусгай		дунд	0	0	0	1	1 (3.7)
Дээд боловсролтой			3	8	3	3	17 (62.9)
Гэрлэлтийн байдал							
Гэр бүлтэй			1	6	4	5	16 (59.3)
Огт гэрлээгүй (ганц бие)			1	1	0	1	3 (11.1)
Салсан			0	1	0	2	3 (11.1)
Бэлэвсэн			0	0	0	3	3 (11.1)
Хамтран амьдрагчтай			1	1	0	0	2 (7.4)
Гэртээ хэнтэйгээ хамт амьдардаг эсэх							
Нөхөр/ эхнэрийн хамт			1	0	2	2	5 (18.5)
Нөхөр/ Эхнэр, хүүхдүүдийн			0	6	2	3	11 (40.7)
Ганц бие			0	1	0	3	4 (14.8)
Хамаатан садан			0	0	0	1	1 (3.7)
Хамтран амьдрагчтай			1	1	0	0	2 (7.4)
Бусад			1	1	0	2	4 (14.8)

Ахуйн нөхцөл байдал					
Өөрийн гэрт	1	1	1	1	4 (14.8)
Өөрийн хашаа байшинд	0	1	1	4	6 (22.2)
Орон сууцанд	1	4	2	5	12 (44.4)
Түрээсийн байранд	1	2	0	1	4 (14.8)
Бусад	0	1	0	0	1 (3.7)
Ажил, эрхлэлтийн байдал					
Удирдах	0	0	0	0	0 (0)
Мэргэжилтэн	3	8	3	2	16 (59.3)
Ажилчин	0	1	1	9	11 (40.7)
Ажилсан жил					
1-5	3	7	2	7	19 (70.4)
6-10	0	1	1	1	3 (11.1)
11<	0	1	1	3	5 (18.5)

2. Ажлын байран дахь стрессийн түвшин

Албан хаагчдын ажлын орчноос үүдэлтэй сэтгэл гутралын түвшин маш бага 74.1% (n=20), түгшилтийн түвшин мөн адил маш бага 59.3% (n=16), стрессийн түвшин бага 33.3% (n=9) байв (Зураг-1,2,3).



Дүгнэлт:

1. Ажлын орчноос үүдэлтэй сэтгэл гутрал маш бага, бага гарсан нь албан хаагчд дунд ажлын орчноос шалтгаалсан сэтгэл гутралын ноцтой эрсдэл бага байгааг харуулж байна. Байгууллагад сэтгэлээр унах, хэт ядарч, итгэл алдах эрсдэл бага.
2. Ажлын орчноос үүдэлтэй айдас, түгшүүр нь ихэнх албан хаагчдад маш бага болон бага гарсан боловч 4 албан хаагчд дунд болон өндөр гарч байгаа нь ажлын ачаалал, мэргэжлийн онцлог, ажлын байрны тодорхой бус байдал эсвэл хүн хоорондын харилцааны асуудлаас шалтгаалсан байж болно. Тиймээс шалтгааныг тодруулж анхаарах хэрэгтэй.
3. Стрессийн түвшин ерөнхийдөө бага гарсан боловч 4 албан хаагчд маш өндөр болон өндөр гарсан нь ажлын зохион байгуулалт, ажлын ачаалал, мэргэжлийн онцлог зэргээс шалтгаалсан байж болох ба стресс менежмент хийх чадварт суралцах хэрэгцээ байгааг харуулж байна.

Нийт албан хаагчдын 78.9 хувь нь тус байгууллагад 3 буюу түүнээс дээш жил ажилласан, гүйцэтгэх албан тушаалтнуудын 36.3% нь эрдмийн зэрэгтэй байгаа нь мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх үзүүлэлтийн хувьд хангалттай үр дүн юм.




График-2




График-3

Байгууллагын хүний нөөцийн нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөв мөнгөний хүрэлцээгүй байдал сөргөөр нөлөөлдөг. Мөн залуу ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахад нэн шаардлагатай зүйл нь хөнгөлөлттэй нөхцөлөөр байр, орон сууцтай болох, гэр оронгүй иргэдтэй ажиллах гадаад улс орны хамтын ажиллагааг хөгжүүлэх, танилцах туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдийн хандлагыг өөрчлөхөд нөлөө үзүүлэхүйц орчин нөхцөлийг бий болгоход анхаарч ажиллах хэрэгцээнүүд ажил үйлчилгээтэй уялдан гарч ирж байна.

Төвийн шинэ байр ашиглалтанд орсноор хүний нөөцийн бүтэц, орон тоо болон ажиллах орчны таатай байдал нэмэгдэх тул хүлээгдэж буй үр дүнг бодит болгох нь 2025 оны тулгамдсан асуудал, нэн тэргүүний шаардлага болж байна.

Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйлс, нөлөөлөл

№	Хүчин зүйлс	Нөлөөлөл/тайлбар
1	Удирдлагын чиг үүргийг зохион	- Удирдлагаас чиг үүргийг зөв зохион байгуулж ажилладаг - Ардчилсан нээлттэй удирдлагын арга барил хэрэглэдэг - Урьдчилан төлөвлөсөн ажлын дарааллаар ажлаа гүйцэтгэх гэхээр цаг үеийн олон ажил гарч ирдэг

	байгуулах, хангаж ажиллах, мэдээлэх	Удирдлагын зүгээс чиг үүргийг зөв зохион байгуулдаг хэдий ч нэг ажилтан хэтэрхий олон үүрэг даалгавар гүйцэтгэдэг
2	Чиг үүрэг	- Ажлын байрын тодорхойлолтод заасны дагуу ажилладаг - Өөр чиг үүргийн ажлыг олон удаа давтан хийдэг - Үндсэн ажлаа сайн хийж байтал санхүүгийн холбоотой янз бүрийн материал авах шаардалага гарч ирж хүндрэл үүсгэдэг - Албан хаагчид болон үйлчлүүлэгч 2-ын бүхий л ажилд оролцдог, тулж ажилж амжихгүй, чадахгүй зүйлс гардаг - Үндсэн чиг үүрэг ойлгомжтой, ажлын байрны тодорхойлолтод нийцдэггүй олон зүйл байна. - Үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн орчин ойлгомжгүй
3	Ажилтнуудын уялдаа, хамтын ажиллагаа	- Уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайн - Ажлын уялдаа холбоо хангалттай сайн. Харилцааны тал дээр анхаарах - Ажилтнуудын уялдаа холбоо сул түүнийг сайжруулбал хамтын ажиллагаа илүү сайжирна, зарим ажилтнууд ёс зүй сул - Хамтран ажиллахад хүндрэлтэй байна. - Хамтын үйл ажиллагаа, ажил үүргээ тэргүүнд тавьж анхаарах
4	Албан хаагчдын ажилдаа хандах хандлага	- Албан хаагчдын ажилдаа хандах хандлага сайн - Зарим ажилтнуудын ажилдаа хандах хандлага сул - Бусдад хүндрэл учруулахгүйгээр хамт олны эерэг уур амьсгалыг хамгаалж ажиллах
5	Санхүүгийн нөөц	- Сургалт, соёл, хүмүүжлийн үйл ажиллагаа зохион байгуулах зардал төсөвт суудаггүй - Санхүүгийн нөөц маш хомс, энэ асуудал ажилтнуудад тулгардаг - Мэдэхгүй байна
6	Хүний нөөцийн хүрэлцээ, ур чадвар	- Хүний нөөцийн хүрэлцээ дутмаг, дээд байгууллагаас ирэх бичиг, нэмэлт ажил их, ажлын ачаалал өндөр - Хүний нөөцийн ур чадвар сайн
7	Үйлчлүүлэгчдийн санал санаачлага, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хийж буй арга хэмжээ	- Үйлчлүүлэгч иргэдийн оролцоог дэмжих ажил сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа - Үйлчлүүлэгч иргэдийн зөвлөлтэй болсон, иргэдийн санал санаачлагыг тогтмол дэмжиж ажилладаг, удирдлагын зүгээс иргэдийн саналыг үйл ажиллагаанд тусгаж ажилладаг - Санал, хүсэлтийн дагуу их ажилладаг - Удирдлагын зүгээс үйлчлүүлэгч иргэдийн саналыг сайн сонсож анхаардаг боловч ажилтнаа сонсож анхаарал хандуулах нь бага - Үйлчлүүлэгч иргэдийн санал, санаачлага оролцоог нэмэгдүүлэх талаар ажил сайн зохион байгуулдаг - Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр ажилладаг
8	Үйлчлүүлэгчдийн оролцоо	- Хөдөлмөр эрхлэлтийн тал дээр иргэдийн оролцоо сайн - Иргэдийн оролцоо дутмаг - Зохион байгууллалттай ажил үйлчилгээнд иргэдийн санал санаачлага оролцоо боломжийн байгаа - Иргэдийн оролцоо орчны цэвэрлэгээ үйлчилгээнд хангалтгүй байдаг.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн ажиллах орчин, аж ахуйн нөхцөл байдал

№	Агуулга	Шалтгаан
1	Ажлын байр	- Ажлын байрны орчин, гэрэлтүүлэг, агааржуулалт, эрүүл ахуйн шаардлагад нийцдэггүй, эрсдэлтэй - Ажлын байр стандартын дагуу баймаар байна - Агуулах, түлээ нүүрс, эд зүйлс хураах агуулах сав дутмаг - Гэнэтийн гамшиг, осол гарвал байр нурах эрсдэлтэй
2	Техник хэрэгсэл	- Бичиг хэрэгсэл дутуу - Дунд - Сайн - Ширээ, сандал, залгуурууд, проектортой болмоор байна
3	Харилцаа холбооны техник хэрэгсэл, интернет сүлжээ	- Хангалттай сайн - Интернетиин сүлжээ муу, орж гардаг
4	Програм хангамж	- Хүртээмж муу - Үйлчлүүлэгч иргэдийн бүртгэлийн програмыг цахим болгож сайжруулах
5	Тээврийн хэрэгсэл	Сайн
6	Санхүү төсөв	- Дунд - Шаардлагатай гэсэн үйлчилгээнүүд дээр төсөв тавьж өгөх - Дутмаг

Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгийн жагсаалт

Холбогдох хуулиуд

1. Монгол Улсын Үндсэн Үндсэн хууль
2. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Төрийн албаны тухай хууль
6. Хөдөлмөрийн тухай хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Захиргааны ерөнхий хууль;
9. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
11. Хууль тогтоомжийн тухай хууль;
12. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
13. Олон улсын гэрээний тухай хууль;
14. Нийгмийн халамжийн тухай хууль
15. Эрүүл мэндийн тухай хууль
16. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль
17. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
18. Газрын тухай хууль
19. Ойн тухай хууль
20. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
21. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Холбогдох тогтоол, захирамжууд

1. Засгийн газрын тогтоол №138 (2003 он)
2. Нийслэлийн Засаг даргын захирамж №417 (2003 он)
3. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоол №117 (2015 он)
4. Нийслэлийн Засаг даргын захирамж №1338 (2024 он)
5. Нийслэлийн Засаг даргын захирамж №158 (2025 он)
6. Засгийн газрын тогтоол №246 “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” 2021.12.30
7. Засгийн газрын тогтоол №33 “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”. 2019.01.23
8. Засгийн газрын тогтоол №216 “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”. 2020.12.16
9. Засгийн газрын тогтоол №217 “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”. 2020.12.16
10. Засгийн газрын тогтоол №218 “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”. 2020.12.16
11. ЗГХЭГ даргын тушаал №100 “Стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, тайлангийн загварууд”. 2020.12.31
12. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол №65 “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”. 2022.02.22
13. НЗД захирамж №А/1049 “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай”. 2022.08.15
14. НЗД захирамж №А/552 “Нийслэлийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас Засгийн газрын шийдвэрийн төсөл санаачлан боловсруулах журам”. 2022.04.22
15. НЗД захирамж №А/52 “Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”. 2022.02.02
16. НИТХ тогтоол №66 “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”. 2014.05.05
17. НЗД захирамж №А/277 “Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүн, хуралдааны журам”. 2022.02.28
18. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол. 2025.01.29